



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/09

Батширээт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны А/737 тушаалаар батлагдсан "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэсэн талбайг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Гантуяа - Батширээт Сум дундын Ойн ангийн дарга


Гишүүд: Б.Мөнх-Очир - Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Б.Тулга - Байгаль хамгаалагч

2. Үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэсэн талбайг хүлээн авч "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу гүйцэтгэлийн акт үйлдэхийг ажлын хэсгийн ахлагч (Г.Гантуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАЛТАНГЭРЭЛ



232601017